



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/34

Бэрх хот

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн хяналтын улсын үзлэг, тооллогыг явуулах тухай

Монгол улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, "Авто тээврийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Хэнтий аймгийн засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус хотын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 16, 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга : Э.Мягмарсүрэн (ЗАА-ны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Болорцэцэг (Татварын улсын

Гишүүд: байцаагч)

М.Түвшинбаяр (Батноров сумын Сум
дундын Цагдаагийн тасгийн замын цагдаагийн
зохицуулагч, ахлах дэслэгч)

Э.Билгүүнбаяр (Батноров сумын Сум
дундын цагдаагийн тасгийн жижүүрийн цагдаа,
дэд ахлагч)

Б.Энхдөл (Байгаль хамгаалагч)

3. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Сумдад батлагдсан хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Батноров сумын сум дундын Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч (Г.Болорсүх)-д даалгасугай.

• 232501034

5. Заагдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураахыг Татварын улсын байцаагч (Б.Болорцэцэг), хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулах, албан хаагчдыг үүрэгжүүлж, хариуцлагатай ажиллуулахыг Батноров сумын сум дундын Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч (Г.Болорсүх) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Дээрх тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын улсын үзлэг, тооллогыг зохион байгуулж 2025 оны 06 дугаар сарын 18-нд ажлын хэсгийн гишүүд илтгэх хуудсыг танилцуулахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧИЙН ОРЛОГЧ



Н.БАХЫТ